

1930-ААД ОНЫ ДҮРВЭХ ХӨДӨЛГӨӨН ГЭГЧ НЬ ЮУ БАЙВ

Д.Авирмэд. Тагнуулын Ерөнхий Газар, Тусгай архив

Өгүүллийн товч агуулга: 1930-аад оны эхэн үед нам, төрийн эрхэнд гарсан зүүнтнүүдээс авч явуулсан алдаатай бодлогын улмаас Монгол оронд эмх замбараагүй байдал үүсч, янз бүрийн бослого, хөдөлгөөнүүд гарах болсны нэг дүрвэх хөдөлгөөн байсан юм. Энэхүү дүрвэх хөдөлгөөн нь Монгол орны хил орчмын ихэнхи аймгуудыг хамарсан байдаг.

Түлхүүр үг: Дүрвэх хөдөлгөөн, дүрвэх, хил даван нүүх, дүрвэн нүүх, гадаадад оргох, хил орчмын аймаг, сум

Монголын түүхийг нэхэн судлан үзэхүйд төдийлөн судлагдаагүй, түүхийн нэгэн хоосон орон зайг нөхөх асуудлуудлын нэг бол дүрвэх хөдөлгөөн юм. Энэхүү үйл явц нь монголын түүхийн бүхий л үеийн туршид явагдаж ирсэн байна. Тухайлбал, МЭӨ 50-аад онд Хүннү нарын, МЭ 330-552 онд Нирун, XVII-XVIII зуунд Торгуудын зэрэг томоохон дүрвэн нүүх хөдөлгөөн явагдаж байсан бөгөөд эдгээр нь өрнө зүг Европ, Дундад Ази, Ижил мөрөн рүү чиглэсэн байжээ. Тэд эргэж ирэлгүй тухайн нутаг оронд суурьшин үлдэж амьдрах болсон байна. Мөн хэмжээ, цар хүрээний хувьд бага дүрвэн нүүх хөдөлгөөнүүд явагдаж байсныг үгүйсгэх аргагүй юм. Энэ нь монголчуудын эрс тэс байгаль, газар зүйн онцлог, түүнд зохицуулан нүүдэллэн амьдарч ирсэнтэй холбоотой болов уу.

Иймд энэхүү өгүүлэлдээ 1930-аад оны дүрвэх хөдөлгөөний талаар тоймлон бичихийг хичээлээ.

Монголд социализм байгуулах Коминтерний оролдлого нь тус орны нийгэм, эдийн засгийн амьдралыг гүнзгий хямралд түлхэн оруулж, тэрхүү хямрал нь богино хугацаанд улс төрийн хямрал болон гүнзгийрчээ. Хямрал туйлдаа хүрсний гол илрэл нь ард олны дунд төр, засгийг эсэргүүцсэн бослого, хөдөлгөөн тасралтгүй гарах болсонд оршиж байв.¹

Энэ мэтчилэн ард олны дургүйцэл янз бүрийн хэлбэрээр илэрч байсны нэг нь дүрвэх хөдөлгөөн бөгөөд 1930 оны эцсээс Өмнөговь, Алтай зэрэг аймгаас ард иргэд олноороо хил даван нүүх, дүрвэх зэрэг үзэгдэл гарч эхэлсэн байна.

1932 оны дунд үе хүртэл үргэлжилсэн энэхүү дүрвэх хөдөлгөөнд Монгол Улсын хилийн дагуу орших засаг захиргааны одоогийн хуваариар Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Сүхбаатар, Дорноговь, Дундговь, Дорнод, Өмнөговь, Хөвсгөл зэрэг аймгууд хамрагдсан бөгөөд 20 орчим мянган хүн эх нутгаасаа дүрвэн хилийн чанадад гарсан байна.² Эндээс үзвэл хил даван дүрвэх явдал хил залгаа бараг бүх аймгийг хамарсан хөдөлгөөний хэлбэртэй байжээ. Дүрвэгсдийн дотор лам хар, феодал агсад, нам, эвлэлийн гишүүд хүртэл оролцсон байв. Уг хөдөлгөөнд оролцогчид чинээлэг ард, баячуудын хөрөнгийг хураахын эсрэг байсан төдийгүй Орос зөвлөхүүдээр ажил хэргээ хийлгэхийн эсрэг байсан тухай зарим мэдээнд өгүүлжээ.

Дүрвэгсэд Шинжааны Алтайн Ханас, Эрчис, Чингэл цагаан гол, Мичин уул, Маажинсан, Өвөрмонголын Улаанцавын чуулган, торгуудын нутагт амьдрах болсон байна.

Хүн амын дунд эх нутгаасаа нүүж дүрвэх хөдөлгөөн болон бослого үймээн тасралтгүй гарах болсон нь нам, төрөөс явуулж буй бодлого, үйл ажиллагааг яаралтай хянан үзэх шаардлагатай болсны нэн тод дохио, санамж мөн байв. Гэтэл нам, төрийн удирдлагад байсан “зүүнтнүүд” бий болсон нөхцөл байдлыг хайхарч үзээгүйгээр барахгүй бослого хөдөлгөөн гарч байгаа нь ангийн тэмцэл зүй ёсоор хурцдаж, улс орны хөгжил зөв замаар явж байгаагийн илрэл гэж үзэж байлаа.³

¹ Ч.Дашдаваа. Улаан түүх. УБ., 2003, т. 247

² А.Алтанхуяг, Я.Батсуурь. Аюулгүйн байдлын манаанд-80 жил. УБ., 2002, т. 54

³ Ч.Дашдаваа. Улаан түүх. УБ., 2003, т. 248

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Дүрвэгсдийн хөдөлгөөнийг газар нутгийнх нь байршил, зан заншил, үйл явцын эхлэл өрнөлийнх нь онцлогоор ялгаварлан баруун ба баруун өмнө, зүүн ба зүүн өмнө чиглэлээр хоёр хэсэгт хуваан үзэж болох юм.

Баруун ба баруун өмнө чиглэлд:

Дээрх чиглэлд одоогийн Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Завхан аймгийн ард олон хамрагдан оролцсон байна. Тухайн үед дээрх аймгуудын /1931 оны орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлтөөр Баян-Өлгий нь Ховд, Баянхонгор нь Өвөрхангай аймагт харъяалагдаж байв/ 81 сум, 7 хошуунд 500 мянга орчим хүн ам оршин суух ба Амарбуянт зэрэг нөлөө бүхий сүм хийд олон байсны зэрэгцээ гадаадын харъяатууд нилээд хэмжээгээр суурьшсан байжээ.

Тус баруун хязгаар нь хятадын Шиньжаан мужтай хил залгаа орших бөгөөд нөхцөл байдал хүнд болохын дээр хэсэг бүлгээрээ нэгдсэн чантуу, хуйхуу нарын үйл ажиллагаа нь дээрмийн шинжтэй болж, энэ нь сүүлдээ лал шашинтныг авран хамгаалах нэрийдлээр бусад шашинтныг түрэмгийлэн дээрэмдэх нь өргөжиж, үүнд тус улсын харъяат хасгуудаас идэвхтэй оролцож харилцаа холбоо тогтоон хил хязгаарыг хулгайгаар орж гарах нь ихсэж ялангуяа хасгийн ноёдуудаас тэргүүлэн ард олныг элдвээр үймүүлэн хатгаж дагалдуулахыг ихээхэн оролдох болжээ.

Дүрвэх хөдөлгөөн бүр 1929 оны намраас эхлэн Буданчийн хүрээний зарим лам, мяндагтнууд ард олныг хутган үймүүлж, Шинжаанд дүрвэн нүүж очихыг ятгаж байв. Шинжаанд дүрвэн гарсан ноён Гомбо-Очир дүрвэн гарах явдалд идэвхтэй оролцож Эрэгдэл, Балдан, Пэлжид нарын зэрэг хүмүүс нийт лам 11, хар 21 хүний бүрэлдэхүүнтэй эсэргүү үйл ажиллагааг удирдах төв гэгчийг байгуулж байжээ. Үрүмчид нууцаар хүмүүсийг явуулж холбоо бариулжээ. 1930 оны хавар Буданч нутгийн ардуудыг нэгэн зэрэг нүүлгэн хил давуулахаар төлөвлөж бэлтгэсэн байсан бөгөөд Булган, Үенчийнхний ихэнх нь нүүсэн байна. Тэнд МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Б.Элдэв-Очирын удирдлагаар энэ эсэргүү хөдөлгөөнийг зогсоож тохижуулсан юм.⁴

1930 онд Хасагийн Щеруш хошууны захирагч Далилхан, Урианхайн хошууны захирагч да лам Чүлтэм нар Алтайг давсан нь хасгийн ноёд баячууд болон баруун хязгаарын ард түмнээс нийтээрээ дүрвэн нүүхийн эхлэл болжээ.

Урианхай болон хасаг нараас дүрвэн гарсан талаар өөр нэгэн баримтанд өгүүлэхдээ: "... урианхайн 7 хошуу нийлээд нутгийн захиргаа байгуулсан. Харин хасаг, урианхайд мэргэн хэмээн тооцогдсон Чүлтэм да лам нь нутгийн ардуудыг дагуулан хятадын зүг явсан тул бид нар чингэж захиргаа байгуулах нь маш нийцэмжгүй ... бас хасгийн Будхар хошууны 10-аад өрх чанагш нүүхээр хятадын харуулын дэргэд буусан хэмээсэн, бас хасаг Будхар хошууны дарга Хуваны бие тус хошууны 100-гаад ардуудыг дагуулан хошуу тамгын хамтаар Алтай давж одсон ба үүний учир шалтгаан нь урианхай Чүлтэм да ламын бие ардуудаа дагуулан явсан, бас манай хасгийн хүн, малын тоо авах хэмээсэн, бага насны охидыг сургуульд явуулах хэмээсэн зүйлүүдээс ардуудыг урьд адил элдвээр урвуулан төөрөгдүүлж дагуулан явсан болой. Бас хасгийн оргодол Далихан эхнэр хүүхнээ аваачихад мөн нутгийн доторх эсэргүү ангийн этгээд болох Жирбай нарын зэрэг этгээдээс тэдэнд үлэмжхэнээр туслав ..."⁵ хэмээжээ.

1931 онд орон нутгийн засаг захиргааны өөрчлөлт хийж, Увс аймаг бие даан аймаг болсон байна. Засаг захиргааны энэхүү өөрчлөлтийг нутгийн лам, феодалууд эсэргүүцэн тэмцэж байсан бөгөөд мөн оны хавраас эхлэн Ховд аймаг дахь казакуудын 80 гаруй хувь нь Шинжаан Алтайд дүрвэн гарчээ.

Дүрвэгсдийг тэргүүлэн авч гарсан оргодлууд хилийн чанадад гармагц эргэн довтлож нутгийн олныг хүч түрэн түйвээн авч буцах болжээ. Тэд нараас мөн зэвсгийн хүч хэрэглэхийн зэрэгцээ ард олныг дотроос нь өдөөн хатгах аргыг хослон хэрэглэх болсон

⁴ Д.Хүүхэнбаатар. Монголын түүхийн хураангуй хэрэглүүн /1924-1940 он/ УБ., 2000, т. 32

⁵ УТА. Ф-11. Д-1. Хн-229, т. 6-8

байна. Зарим баримтыг иш татахад: Урианхайн хошууны Давст нуур сумын ардууд цуурхал, хүчинд автагдан 1930 оны V сарын 12-нд гэнэт бөөнөөр нүүдэллэн Түргэн хэмээх газар, улсын хилд дөхөн буугаад байсан үед ард олны дунд “VI сарын 22, 23-ний өдрүүдэд чанд талаас, Булган голын . . . хөвөөнд 300 хасаг цэрэг довтлон ирж буудалсан гэнэ” гэсэн цуурхал тарсан нь тэднийг дүрвэхэд нь хүчтэй нөлөөлсөн байна⁶.

Мөн онд баруун хязгаарын хошуудаас дүрвэсэн талаар дилав хутагт Жамсранжав дуртгалдаа: “1931 онд Ар Монголын өмнө захын Дарьганга, Говь мэргэн ван, Түшээт ван Балдан засаг, Үйзэн ван, Ламын гэгээн, Мэргэн ноён хутагт, Жонон ван, Ёст бэйл, Итгэмжит бэйс, Засагт хан, Урианхайн дайчин ван Жамба гүн, Ховдын харъяат Алтайн торгуудын хоёр хошуу, Булганы урианхайн нарын нэг мянга илүү айл, түмэн илүү ам хүн улаан үзлээс дутаан гарч Өвөрмонголын Шилийн гол, Улаан цав хоёр чуулган, Цахар, Альшаа, Эзний голын торгууд, Ганьсу мужийн Маажинсан уул, шар хар хоёр Уйгар /Жунгар/ Шинжаан муж зэргийн газруудад дутаан явав”⁷ гэжээ.

Үүний зэрэгцээ Алтай аймгийн өмнө хязгаараар 1931-1932 онд мөн аймгийн арваад сумаас /зарим сум бүтнээрээ/ 1800 гаруй өрх, Амарбуянт зэрэг хийдийн лам нар гадаадад дүрвэн Маажинсангийн орчим очсны дотор 2282 хүн ам, 1125 тэмээ, 1246 адуу, 881 үхэр, 20858 хонь, 11561 ямаа бүгд 35571 толгой мал бүхий 669 өрх айл, Амарбуянт хийдийн 1238 лам 1932 оны I улирлын хугацаанд дүрвэн гарсан байна⁸.

1932 оны эхнээс эхлэн Алтайн зүүн өмнө талын Жинст, Баян-Өндөр, Цогт, Цээл, Төгрөг сумын ардуудын дотор гадаадад дүрвэн гарахыг уриалсан ухуулга хийгдэж нам, засгийн бодлогод дургүйцэн залхсан ардууд хилийн чанадад гарч амар жимэр амьдрахыг хүсэх болов. Тэд хил гарахдаа хил хязгаарын цэрэг, цагдааг дээрэмдэн тонож, заримынх нь амь насыг бүрэлгэн зэвсэглэж мал, эд хогшлыг нь авч гарах болжээ. Дүрвэсэн ардууд усгүй цөлд малаа цувруулан хаяж, үгүйрэн хоосорч нүүсэн нь улам хүнд байдалд орж байв.

Энэ үед Өвөрхангай аймгийн хувьсгалын эсэргүүчүүдийн нөлөөнд автагдан 1930-1931 онд 120 орчим өрх айл эх орноосоо дүрвэхэд хүргэсэн байна. Мөн 1931 оны үед Баянзүрхийн ардууд удаа дараа гадаадад дүрвэн гарсан байна. Тэдгээр ардуудын нэгэн удаагийн дүрвэн явсныг Цэцэрлэг хэлтсийн мэдээнээс авч үзвэл: “өрх 47, бүх ам 206, эрэгтэй 99, эмэгтэй 107, нам эвлэлийн 5, артелийн гишүүн 8, тэмээ 336, адуу 29, үхэр 13, хонь 1050, ямаа 1435” гэсэн бол тус Баянзүрхийн хошууны харъяат урьд хязгаарт оргох гэж байгаад баригдсан Довдон, Чүлтэм нараас тодорхойлохдоо: “Баянзүрх, Гурвансайхан, Хан хөгшин эдгээр хошуудаас нийт 600 хэр өрх хязгаар нэвтрэн оргосон ба эдний оргосон шалтгаан нь ардын засгаас ангижрахын тулд оргосон”⁹ гэжээ.

Өмнө дурдсан дүрвэх хөдөлгөөний үйл ажиллагаанаас үзэхэд 1933 он хүртэлх хугацаанд БНМАУ-ын баруун ба баруун өмнө талын аймгуудаас бүрэн бус тоогоор 7000-аад өрх айл буюу 1 өрхөд дунджаар 3-4 хүнтэй гэж тооцоход 28000 орчим айл дүрвэн гарсан байна.

Өмнө, зүүн өмнө чиглэлд:

Тус чиглэлд одоогийн Өмнөговь, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгийн ард олон хамрагдсан байна. Мөн чиглэлээр эртнээс нааш монгол улсаас гадаадад харилцах аяны зам харгуй дайрч өнгөрдөг хөл хөдөлгөөн ихтэй, олон үндэстэн ястан амьдарч ирсэн онцлогтойн гадна гадаадын харъяат буюу тус улсад амьдрахаар нүүж ирэгсэд олноор суурьшиж байжээ.

⁶ ТЕГ. ТА. Сан-1. Д-ЭТХ. Хн-7. т. 96

⁷ Дилав хутагт Жамсранжав. Ар Монголын улс төрийн дуртгал. УБ., 1991, т. 54

⁸ С.Бат-Очир, Э.Лувсанбалдан, Ш.Арвай. Монгол Улсын хил хамгаалалтын түүхэн тэмдэглэл. УБ., 1995. т. 110

⁹ ТЕГ. ТА. Сан-1-18-3. Хн-5. т. 3-5

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

1930-1931 оны байдлаар Өмнөговь, Хэнтий, Дорнод аймгийн 193 хүрээ хийд, 30 гаруй мянган ламтай байсан нь улсын хэмжээний хүрээ хийдийн 20-иод, лам нарын 30-аад хувийг эзэлж байсан байна.

Тус Монгол улсад буриад, халимагууд дагаар орох нь ихэссэн нөхцөл байдлын улмаас 1930 оны V сарын 26-нд БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газруудын хооронд дагаар орогчдын талаар тогтоол гаргаж, энэ хэлэлцээрийн дагуу 1930 оны сүүлчээс эхлэн Гомбобадамжав, Цогтбадамжав, Даш Сампилон зэрэг Монголын харъяат нэгэнт болсон буриад хүмүүсийг зөвлөлтийн тал татаж эхэлсэн нь манай улсад дагаар орогчдын сэтгэл санааг тогтворгүй болгоход нөлөөлсөн байна. Түүгээр ч үл барам монголын зарим феодал, лам нар харийн нутагт оргон гарахыг ухуулж ятгах үйлдлийг гаргах болжээ. 1930 оны хавар Хан хэнтий уулын аймгийн Эрдэнэцагаан уулын хошууны /одоогийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум/ тойн Содном гэгч “Замын-Үүд, Дарьгангын нутгийг дайран хятадын их цэрэг ардын засгийг устгахаар хойш гарч байна. Одоо та нар амиа боддог цаг болоод байна” хэмээн Далайбулаг, Шар хадны заставынхны дунд ятган оргуулах ажлыг зохион байгуулжээ. Энэ талаарх мэдээг авсан Баянтүмэний Дотоодыг хамгаалах анги нь хошууны нам, эвлэлийн хороо, Чоно голын 19 дүгээр сумантай хамтран урьдчилан сэргийлэх ажил зохиож, Бүх Цэргийн Зөвлөлийн Тэргүүлэгч Т.Дэмид даргалсан Засгийн газрын бүрэн эрхт комисс газар дээр нь хэргийг шалгаж тойн Содном, Далайбулагийн заставын дарга хоёрыг хуулийн дээд, бусад холбогдогчдыг хорих ялаар шийтгэжээ.

Дээрх нөхцөл байдлын үед Өмнөговь аймгийн Хүрмэн, Баян-Овоо болон хилийн бусад сумдад “Өндөр бөө” хэмээх Гончиг, “алаг” Намнан, “Ганжуурва хувилгаан” хэмээх Г.Цэрэн нараар толгойлуулсан нөлөө бүхий лам нар гүтгэлэг цуурхал тарааж “Банчин богдын дэргэд очиж шашныг мандуулан хуучин төрийг байгуулж жаргалтай сайхан амьдарна” гэсэн ухуулга хийж “Банчин ринбүүчийн тамга” гэгчийг хуурамчаар үйлдэж ухвар мөчид ардуудыг төөрөгдүүлэхдээ ашиглаж байсан байна.

Тус аймгийн баруун ба баруун өмнө, өмнө талыг хамарсан дүрвэх хөдөлгөөн нь “алаг Намнангийн хөдөлгөөн” гэж орон нутагт нэрлэж байв. Энэхүү хөдөлгөөнийг анх санаачлагч бөгөөд үүсгэгч нь хувилгаан Очирдарь лам юм. Тэрээр хуучин Сайн ноён хан аймгийн Балдан засгийн хошуу, одоогийн Өмнөговь аймгийн Хүрмэн сумын харъяат Пунцаг тойны хүү Түвдэн хэмээх бөгөөд говь Гурвансайхан уулын баруун өмнө өвөрт орших Балдан засгийн хошуу хийд /Гүж ламын/ дээр бага насандаа хувилгаанаар залагдан ойр хавийн ардуудыг эрхшээлдээ оруулан мунхруулж бишрэн шүтэгдэж ихээхэн эрх тушаалыг эдэлж байсан байна. Гэтэл Монголд үндэсний ардчилсан хувьсгал ялж эрх тушаалаа хасуулсандаа хорсон Банчин богдтой харилцан ардын засгийг унагаах, ингэхдээ юуны өмнө бослого хөдөлгөөнийг зохион байгуулах нь чухал гэж үзжээ. Энэхүү ажилдаа хөрөнгөө хураалгасан мээрэн Чанарав, “алаг” Намнан, Чойжин лам нарыг ашиглажээ.

Энэ үед аймгийн зүүн талын Өлзийт /тухайн үед Өмнөговь аймгийн харьяанд байв/, урд талын Номгон, баруун талын Хүрмэн, Баяндалай зэрэг сумдаас ардууд ихээр дүрвэн гарах болов. Тэд анх 1931 оны зун Хүрмэн сумын харъяат алаг Намнан, өндөр Бөө, нуухан Шар зэрэг хүмүүсээр удирдуулан хэдэн зуугаараа дүрвэн хилийн чанадад гарчээ.

Мөн тус аймгийн сүм, хийдэд шавилан суух лам нар аймгийн ард, иргэдэд худал цуурхал тараан дүрвэхэд нь нөлөөлж байжээ. Тухайлбал, “... Өмнөговь аймгийн Жавхлант, Баянбулаг, Хүрмэн, Хонгор зэрэг сумдын зах хязгаарт ардууд ба бас Байшинт зэрэг хийд сүмдийн лам нараас гадаадад буй Намнан, Ганжуур хувилгаан нар бид нарыг Монголын хуучин цагаан сарыг гарсан даруй цэрэгтэй ирж авах гэнэ билээ. Иймд бид нар эндээс нутгийн хилд ойр нутаглах хэрэгтэй хэмээн энэ завсарт энгийн номхон суугаа ард олны санаа сэтгэлийг далдуур битүүлгээр ятгаж урвуулах, үймүүлэх ба мөн зарим нь гадаадад оргосон ах ба багш нар лугаа дам харилцан уулзах зэргийн явдлууд нь одоо үед цөөнгүйгээр үзэгдэх болсон...”¹⁰ хэмээсэн байна.

¹⁰ ТЕГ. ТА. Сан-1. Д-1-19-2. Хн-2, т. 6-9

Энэ явдлаас хойш хэсэг хэсгээрээ гадаадад оргон дүрвэх явдал тасралтгүй үргэлжлэх болсон бөгөөд тус аймаг дахь Дотоодыг хамгаалах хэлтсийн 1932 оны илтгэлд бүрэн бус мэдээгээр 1931 онд 1864 хүнтэй 302 өрх айл гадаадад дүрвэн гарсан тухай тэмдэглэжээ.¹¹ Энэ үест төр засгийн бодлого, шийдвэрийг эсэргүүцэгчид үйл ажиллагаагаа идэвхжүүлж гадаадад оргон гарсан нөлөө бүхий хүмүүстэй холбоо тогтоон тусламж авч олон тооны зэвсэгт дээрэмчдийн хүчээр хилийн харуул манааг довтолж, нутгийн гүнд сэм нэвтэрч ардуудыг айлган сүрдүүлэх, хууран мэхлэх аргаар гадаадад авч гарч байв.

Судалгаанаас үзэхэд Өмнөговь аймгаас бүрэн бус тоогоор 1800 орчим өрх ам бүхий 7200-аад хүн хилийн чанадад дүрвэн гарчээ.

“Алаг” хэмээх М.Намнангаас 1935 оны XII сарын 3-нд тус аймгаас дүрвэн гарсан өрх айлуудын талаар тодорхойлохдоо: “. . . торгууд Ма Цүн Шияны нутагт хуучин жонон вангийн харъяат 100 хэр өрх айл . . . торгуудын Эзний голд Гурвансайхны Ноён богд гэдэг газраас оргосон 50-60 хэр өрх айл . . . Альша нутагт Хонгор, Хүрмэн сумдын 60 хэр өрх айл . . . Дунд гүний хошуунд Баянзүрхийн 40, жонон вангийн 20, Ёстын 30 хэр өрх айл . . . Дархан бэйлийн нутагт Гурван сайхан, Ёст бэйлийн 50-60 хэр өрх айл . . . Батхаалга хавьд Ганжирва, баян Содном нарын захирсан 100 гаруй өрх байв . . .” гэжээ¹². Энэхүү баримтыг нягталбал, тус аймгаас урд зүг хилийн чанадад тав арваараа болон хэдэн зуугаараа дүрвэж байсан ба эдгээр өрх айлуудын тоо нь бүрэн бус тоо болох нь ойлгомжтой. Харин тус баримт нь дүрвэсэн өрх айлууд ихэвчлэн хаана, ямар газар байрлаж байсныг тодруулах бололцоог олгож байна.

Ингэж эхэлсэн хөдөлгөөн газар авч Дундговь аймгаас 1932 оны II сарын байдлаар 296 хүн, 1931-1934 онд Дорнод аймгийн Дарьганга, Хонгор, Молцог, Улаануур, Урт, Баяндэлгэр, Асгат, Эрдэнэцагаан, Тамсагбулагийн хязгаараас 801 хүн /голлон буриад өрх/ болон Хэнтий аймгийн харъяат хүмүүсч уг хөдөлгөөнд хамрагджээ.

Мөн Дорноговь аймаг дахь дотоодын эсэргүү нар янз бүрийн ухуулга, цуурхал тарааж, нутгийн ард түмнийг эх орноос нь урвуулах ятгалгыг хийсний уршгаар 1931-1932 оны VI сар буюу шинэ эргэлтийн бодлого явагдах хүртэл тус аймгаас 228 хүнтэй 54 өрх айл, 637 бод, 200 гаруй бог мал авч хил нэвтрэн өвөрмонголын нутагт дүрвэсэн байв.¹³

Эдгээр аймгуудаас дүрвэгсэд нь Банчин богд ба Нанхины засгийн газраас нутаг гуйсанд Улаанцавын чуулганы нутгаас нутаг олгосон байна.¹⁴ Мөн Өмнөговь аймгаас дүрвэн гарсан баян Содном нарын 40 орчим өрх айл Уртын хошууны Галт овооны энгэрт, Дорнод аймгаас дүрвэгсэд Шинэхэний нутагт, “алаг” Намнан, феодал Чойжин нарын хэсэг Альшаа хошуунд дагаар орж Шаргийн сүм зэрэг газар нутаглаж байв¹⁵. Энэ бүхний эцэст 1935 оны байдлаар 5-6 мянган хүн амтай 1000 орчим өрх айл дүрвэн явж, тэднээс 4000 орчим хүн Улаанцавын чуулганд, 2000-гаад нь Торгуудын нутагт амьдрах болжээ.¹⁶

Өмнө өгүүлснээс үзэхэд дүрвэгсдийн хөдөлгөөнд баруун хязгаарын ард түмэн илүү оролцож байгаа нь харагдаж байна. Энэ нь газар нутаг болоод зан заншлын өвөрмөц онцлогтой холбоотой бололтой бөгөөд түүхийн улбаанаас авч үзвэл төвөөс өөрсдийгөө тусгаарлан бие даах гэсэнтэй ч холбоотой байж болох юм.

Ямар ч байсан баруун монголын ард иргэд нь Монголын салшгүй нэг хэсэг бөгөөд тус дүрвэх хөдөлгөөнд хил орчмын бүх аймгууд хамрагдсан ба үр дагавар, улс төрийн шинж чанарын хувьд өргөн далайцтай үйл явц байсан юм.

XX зууны нэрт эрдэмтэн Ж.Цэвээн төрөлх нутгаасаа дүрвэн гарагчдын хувь заяа хэрхэснийг дүгнэн хэлэхдээ: “. . . Монголын олон аймгуудын газар нутаг лугаа нийлэлцэх мэт үзэгдэвч, зарим нь Орос улсын захиргаанд орж газар ус ба өөрийн үндэсний утга

¹¹ ТЕГ.ТА. Сан-1. Хн-7, т. 3

¹² ТЕГ. ТА. Сан-4. Хн-1559. хавтас 1, т. 5-8

¹³ Мөн архив. Сан-1. Хн-Дугааргүй

¹⁴ Мөн архив. Сан-1. Д-ТХ. Хн-54, т. 96

¹⁵ ТЕГ. ТА. Сан-1-18-2. Хн-2, т. 1

¹⁶ Мөн архив. Сан-1-18-3. Хн-851

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

чанарыг алдахад хүрсэн буюу эсэхүл Хятадын захиргаанд мөн л эл газар ус ба зан суртал юугаа гээхэд хүрч улс төрийг үнэхээр байгуулж чадахгүй буюу дурлах ч үгүй болжээ хэмээхээс гадна . . . цус ясаа хольцолдож удтал суусаар монгол үндэстний шинжийг их төлөв гээжээ . . .”¹⁷ хэмээсэн байна.

Энэ үеийн дүрвэх хөдөлгөөний онцлог нь 1910-аад, 1920-иод оныхтой харьцуулбал өөр дүр зураг ажиглагдана.

1910-аад оны үеийн дүрвэх хөдөлгөөний онцлог нь:

- Манжийн дарлалд удаан хугацаанд нэрвэгдсэн Монгол орон нь хэдийгээр 1911 онд төрийн тусгаар тогтнолоо сэргээсэн боловч эдийн засгийн хүчин чадал дорой, буурай, гадаад, дотоодын дарлал, мөлжлөг туйлдаа хүрч, өлсгөлөн, үгүйрэл хоосрол их хэмжээгээр тохиолдож байсан явдлуудаас шинэ газар, орныг эрэлхийлэн дүрвэн явж байсан.

- Шинэ тулгар төрийг хүлээн зөвшөөрч чадахгүй, түүнтэй санаа нийлэлцэхгүй болсны улмаас ноёд, түшмэд харъяат ард иргэдийг авч дүрвэн явж байсан.

- Нийгмийн тодорхой нэг хэсэг, газар орныг хамарч байсан.

- Тус улсад дагаар орогсдоос Хятадын ухуулга, ятгалгаар буцан явсан дүрвэлт зэргийг нэрлэж болохоор байна.

1920-иод оны үеийн дүрвэх хөдөлгөөний онцлог нь:

- Өмнөх үеийн дүрвэх хөдөлгөөний онцлог шинж чанар нь энэ үед уламжлагдаж ирсэн.

- Ноёд, түшмэдээс дүрвэх хөдөлгөөнд илүүтэйгээр тэргүүлэн оролцох болсон.

Харин 1930-аад оны үеийн дүрвэх хөдөлгөөний өмнөх үеүүдийнхээс ялгагдах онцлог нь:

- Дүрвэлтийн идэвхжилтийн үе буюу дүрвэлт улс орныг бүхэлд нь хамарсан.

- Дүрвэлтэд нийгмийн дунд давхрага болох ард олон хэдэн зуугаараа оролцсон.

- Дүрвэгсдээс сайн дураар эх орондоо эргэж ирж байсан.

Эцэст нь тэмдэглэхэд 1930-аад онд нам, төрийн эрхэнд гарсан зүүнтнээс авч явуулсан алдаатай бодлого, үйл ажиллагаа нь Монгол орны нөхцөл байдалд нийцэхгүй арга хэмжээ болсон төдийгүй, энэ нь улс орныг хямралт байдалд хүргэжээ. Тэрхүү хямралт байдал нь Монголын нийгмийн дотоодод зөрчил, тэмцлийг буй болгосон нь ард олноос зэвсэг барих, дүрвэх зэрэг тэмцэл, хөдөлгөөнийг гаргаж, монгол орныг нэлэнхүйд нь хамарсан бөгөөд судлаачдын бүтээлд 1930-аад оны эхэн үеийн дүрвэх хөдөлгөөнд 7542 өрх буюу 30 мянга гаруй хүн хамрагдсан гэсэн тоо баримт байх бөгөөд судалгаагаар /бүрэн бус мэдээ/ 9800 орчим өрх бүхий 41200-аад хүн хамрагджээ. Энэ тоо нь цаашид өөрчлөгдөхийг үгүйсгэх аргагүй юм.

Abstract

Основная краткая изложения: В начале 1930-ых годов внешние и внутренние обстановки Монголии обострялась от массовых беспорядков и восстаний. Это обострение напрямую зависило от неправильных руководств восточных партий страны и один из этих явлений стало проблема беженцев. Это явление охватывало большинство провинций которые находились в приграничных местах Монголии.

Значимые слова: Проблема беженцев, переселиться за границу, бежать за границу, приграничные провинции.

¹⁷ Ж.Цэвээн. Түүвэр зохиолууд. УБ., 2000. т. 150